



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 16 өдөр

Дугаар A/595

Ховд

Г Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай Г

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт 33 дугаар зүйлийн 33.1.2 зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 5/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Бичигт багийн нутаг дэвсгэр Эрх чөлөө 2 дугаар гудамжны 214 тоотод байрлах 2318 метр квадрат газрыг “Эрчлүүр” ХХК /2033488/-д, авто дромын сургалт талбайн зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрх нь баталгаажсан дээрх аж ахуйн нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/595 Ch
02 02955